

Хүн төрөлхтний хүсэл эрмэлзлийг ардчилал гэдэг зүйл эзэмдэх болсноор олон зуун жил өнгөрч байна. Эргэх цагийн хуулиар Монгол орон маань ч ардчиллын замд орохоор эрвийх дэрвийхээрээ зүтгэж явна. Гэвч мэдэхгүй ойлгохгүйн гачлан зовлонтой алхам тутамдаа тохиолдож байгааг хэлэх хэрэгтэй. Тэгэхлээр эхлээд ардчилал бүрэлдэн тогтсон түүхийг товч хөндөн ярилцвал сонин байж магадгүй.

а) Ардчиллын давалгаа

XVIII зууны сүүлчээр орчин үеийн ардчиллын үндэс суурийг бүрдүүлсэн хоёр чухал тунхаг бичиг Атлантын далайн хоёр этгээдэд бараг зэрэг шахам гарч иржээ. Эдгээр нь Францын хөрөнгөтний хувьсгалаас 1789 оны 8-р сарын 26-нд тунхагласан иргэн ба хүний эрхийн тунхаг, түүнээс сар орчмын дараагаар 9-р сарын 25-нд АНУ-ын анхны ерөнхийлөгч Жорж Вашингтоны тунхагласан эрхийн тухай билль байсан юм. Эдгээр тунхаг бичгийг гүн ухааны түүхэнд Соён гэгээрлийн үе шат гэж нэрлэгдсэн үеийн «хүнд байгалиас олгогдсон эрхийн тухай онол» болон гүн ухааны бусад баримт бичигт тулгуурлан бичсэн байв. Энэхүү хоёр тунхаг нь олон зууны турш хатуу бэрхийг туулж, элдвийн шүүлт шалгаврыг давахдаа ач холбогдлоо алдалгүй өдгөөг хүрчээ. Бүгд найрамдах байгууллын хувь заяа хийгээд эрх чөлөөний ариун галыг сахин хамгаалах явдал америкчууд бидэнд зүй ёсоор ногдлоо гэж тэртээ 1789 онд Жорж Вашингтоны хэлсэн үг эдүгээ биеллээ олсон гэж үзэж болох биз ээ.

Түүхэнд «ардчиллын давалгаа» гэж нэрлэгдсэн үйл явц нь аливаа түүхэн үйл явдлуудын адил өсөлт бууралтын үе шаттай байсан билээ. Тухайлбал, дээр дурдсан түүхэн чухал баримтууд батлагдан гарснаар ардчиллын анхны давалгаа дэлхий дахиныг эзэмдэн авах үеийг даллан дуудсан юм. Анхны давалгаа XIX зууны эхэн үеэс 1920-оод оныг хүртэл буюу АНУ-ын хүн амын эрэгтэйчүүдийн ихэнх нь сонгуулийн эрхээр хангагдсанаас эхлээд 1922 онд Муссолини Италид засгийн эрхэнд орох хүртэл үргэлжилсэн гэж үздэг: Энэ үед дэлхий дээр 29 ардчилсан улс гарч иржээ.

1922 оноос 1942 он хүртэлх үеийг ардчиллын давалгааны ухралтын үе гэж үздэг бөгөөд энэ үед ардчилсан улсын тоо 12 хүртэл буурчээ.

Дэлхийн II дайнд холбоотнууд ялснаар ардчиллын хоёр дахь давалгаа эхэлж, 1962 онд дээд оргилдоо хүрсэн юм. Энэ үед ардчилсан улсуудын тоо 36-д хүрчээ. Ардчиллын давалгааны хоёр дахь ухралт нь 1962 оноос эхэлж, 1970-аад он хүртэл үргэлжилсэн бөгөөд ардчилсан улсын тоо 30 хүртэл буурсан юм.

1974 онд ардчиллын гурав дахь давалгаа эхэлж, ардчилсан улсын тоо 30 орчмоор нэмэгджээ. 80-аад оныг гурав дахь давалгааны оргил үе гэж нэрлэх эсэх нь өнөөдөр хараахан шийдэгдээгүй байна. Түүнч-

* Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан.

лэн ухралтын үе чирэхгүй гэх аргагүй, Америкийн эрдэмтэн Хантингтон, гурав дахь ухралт болзошгүйн адил XXI зуунд ардчиллын дөрөв дэх давалгаа эхэлж мөн болзошгүй гэж үзэж байна.

1990 оны байдлаар тусгаар тогтносон 167 улсаас 61 нь ардчилсан улс гэж тооцогдож байв. Эдгээр улсын хүн ам дэлхийн нийт хүн амын 39 хувийг эзэлдгийг хэлэхэд сонин байж магадгүй. Гэхдээ энэ тоо одоо хуучирсан гэдэг нь ойлгомжтой. Өнөөдөр ардчиллын давалгаа Сенегалаас Ангол, ӨАБНУ хүртэл давалгаалж байна.

б) Америкийн ардчилал гэж юу вэ?

АНУ-ын ерөнхийлөгч агсан Авраам Линкольн-ардчилал бол ард түмний төлөө, ард түмнийг удирдах «ард түмний» засаг юм гэж хэлжээ. Ард түмний өмнөөс ард түмнийг удирдана гэдэг нь ардчилсан нийгмийн иргэд удирдагчдынхаа ололт амжилт бүхнийг нь хуваалцаж, төр засгийн хүнд ачааг хамт үүрэлцэнэ гэсэн үг юм. Учир нь ардчилал дангаараа юуг ч баталгаажуулдаггүй ажээ. Ардчилал хүмүүст аз хийморь, ялагдал гутралын аль алиныг нь адил хэмжээгээр эдлэх боломжийг бүрдүүлдэг зүйл юм. Өөрөөр хэлбэл, Томас Жефферсоны онож хэлснээр, ардчилал гэдэг нь эрх чөлөөтэй амьсгалж, аж төрж, аз жаргалыг эрж хайх боломж билээ. Аливаа улсын ардчиллын түвшин нь улс төрийн ба иргэний эрх чөлөөний цар хүрээгээрээ хэмжигддэг. Иргэд нь тэмцэж олсон эрх чөлөөнийхөө төлөө ямагт санаа тавьж, түүнийгээ нийгмийн амьдралд оролцохын хэрээр ашиглахыг эрмэлзэж байдаг нийгэмд ардчилал амьд сэрүүн цэцэглэн хөгжиж байдаг. Тухайлбал, иргэд нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, төрийн эрх барих төлөөлөгчдөө сонгон тодорхой үүрэг хариуцлага хүлээлгэсэн бол тэдэндээ мөн тэр хэмжээгээр итгэж найдаж, харилцан зохицож, хүлээц тэвчээртэй хандах ёстой. Тодруулж хэлбэл, аливаа ардчилсан улсын иргэд хувийн эрх чөлөө эдлэхийнхээ зэрэгцээ эрх чөлөөт байдал ба өөрөө өөрийгөө удирдах ёсыг бий болгоход чиглэсэн нийтийн хариуцлагыг ч бусадтай хуваалцах ёстой гэдгээ умартаж болохгүй ажээ. Тэгэхээр ардчилсан эрүүл нийгэм нь аль нэгэн хүний хувийн ашиг сонирхлыг хангах тавцан төдий зүйл биш юм.

Хүнд эсрэг тэсрэг хүсэл төрөх нь элбэг тохиолддог. Жишээлбэл, хүмүүс амар жимэр суухыг мөрөөддөг мөртлөө адал явдлыг хүсэх нь бий. Тэд нийгмийн тэгш эрхт байдлыг ихээр шаарддаг мөртлөө хувийн эрх чөлөө өөд ямагт тэмүүлж байдаг. Хүмүүс дотоод ертөнцийнхөө иймэрхүү зөрчилтэй байдалтай ардчиллыг зүйрлүүлж болох бөгөөд ардчилсан аль ч нийгэмд олон зөрчил, тэр ч байтугай эмх замбраагүй байдал орших нь бий. Ардчилал бол зохих зарчим, хэм хэмжээг бий болгомогц л ажиллаад эхэлдэг автомат биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Ардчилсан нийгэм зөрчил тэмцэл, харилцан зохицол, тэсвэр тэвчээрийг хамтад нь хүлээн авахыг хүмүүсээс шаарддаг. Ардчилсан нийгэм дэх зөрчил тэмцлийн олонход зөв, буруугийн ялгаа хийгээд ардчилсан эрх, нийгмийн хязгаарлалтын хоорондох элдэв тайлбарын чухам аль нь будилж мунгинаж яваагийн нарийн учрыг тогтооход хэцүү байдаг. Үүнийг хүлээн зөвшөөрч ойлгох явдал нийгмийн сэтгэхүйд нэн тустай гэж хэлж болно. Ардчилсан нийгэмд хүмүүс хувийн идэвхтэй амьдралынхаа хүрээнд эрх чөлөөтэй байхын баталгаа нь өөрөө өөрийнхөө удирдах ёсноос урган гардаг гол шаардлага буюу иргэдээс нийгмийнхээ өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлэх явдал ажээ.

Ардчилал, эрх чөлөө гэдэг ойлголтуудыг нэгийг нь нөгөөгөөр орлуулах нь элбэг үзэгддэг. Үнэндээ ч энэ хоёр ижил ойлголт юм. Учир нь ардчилал бол эрх чөлөөний тухай үзэл бодол зарчмууд мөнөөс гадна

түүхэн урт хугацаанд бүрэлдэн бий болсон туршлага дадлагын цогц юм. Товчоор хэлбэл, энэ бол хуульчлагдсан эрх чөлөө юм. Энэхүү хуульчлагдсан эрх чөлөө нь цаг хугацаагаар шалгарсан үндсэн хуульт засгийн зарчим, хүний эрх, хуулийн өмнө бүгд тэгш байх ёс зэргийнх нь хэмжүүр болж, тухайн нийгмийг ардчилсан гэж нэрлэх боломж олгодог.

Ардчилал үндсэн хоёр хэлбэртэй. Тэдгээр нь эгэл ардчилал, төлөөлөх ардчилал юм. Ардчиллын эгэл хэлбэр нь сонгосон буюу томилсон хүмүүсээр дамжуулалгүйгээр нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд иргэд шууд оролцдог хэлбэр юм. Гэхдээ энэ нь харьцангуйгаар цөөхөн хүн амтай байгууллыг хамаарах боломжтой байдаг сул талтай. Жишээлбэл, тийм байгуулал нь овог, аймгийн холбоо, хот улс гэх мэт зүйлүүд байж болно. Өөрөөр хэлбэл, харьцангуй цөөн хүн ам нь нэгэн дор цуглаж, харилцан зохицох, эсвэл олонхын саналаар шийдвэр гаргах болмжтой нэгдэл юм. Харин төлөөлөх ардчиллын хувьд бараг яриулалтгүй ойлгогдож байгаа байх аа. Яагаад гэвэл ардчиллын энэ хэлбэр орчин үед дэлхий дахинд хамгийн их тархмал зүйл болсон учраас хүмүүс ямар нэгэн хэмжээгээр түүнтэй танил болчихоод байна. Өөрөөр хэлбэл, энэ хэлбэр нь төрийн дээд байгууллагад сонгогдсон албан тушаалтан тэрхүү албаа ард түмний нэрийн өмнөөс хашиж, ард түмний өмнө хариуцлага хүлээн тайлагнадаг хэлбэр юм.

Ер нь ардчилсан систем гэж иргэд нь олонхын засаглалд дулдуйдан улс төрийн шийдвэр гаргадаг системийг хэлдэг. Гэхдээ энд нэгэн зүйлийг анхаарахад олонхын засаглал тэр бүр ардчилсан шинжтэй байдаггүй. Жишээлбэл, олонхын нэрийн өмнөөс хүн амын 51 хувь нь 49 хувийг дарлах дэглэм тогтоосон систем байвал хэн ч шударга ёс гэж нэрлэхгүй. Тэгэхлээр ардчилсан нийгэмд цөөнхийн эрхийг хамгаалах явдал түүний улс төр, үндэсний хамаарал, шашин шүтлэг, эсвэл хуулийн зүйл анги дээр маргалдсан төдийгөөс цөөнх болсноос хамааралгүйгээр хувь хүний эрхийн тухай хуулиар баталгаажсан байх шаардлагатай. Цөөнхийнхөө эрхийг хуулиар хамгаалсан олонхын засаглал ч ардчилсан шинжтэй байдаг. Түүнчлэн ардчилсан нийгэм цөөнхийн эрхийг олонхын ивээл хишиг гэж үзэж болохгүйн адил түүнийг олонхын саналаар өөрчлөх ёсгүй. Учир нь ардчилсан хууль, хэм хэмжээ нь бүх иргэдийн эрхийг хамгаалж байдаг чанараараа цөөнхийн эрхийг хүндэтгэн хамгаалж байдаг билээ. Энэ тухайд Америкийн эрдэмтэн Диана Рэвич, үндсэн хуулиар Засгийн газрын эрх мэдлийг хязгаарлаж, хүний эрхийг баталгаажуулах хэлбэрээр ажиллаж байгаа төлөвлөх ардчилал нь жинхэнэ төлөөлөх ардчиллын хэлбэр юм. Ийм нийгэмд олонх удирдаж, цөөнхийн эрх хуулиар хамгаалагдаж байдаг гэж бичжээ. Өөрөөр хэлбэл, хэрвээ ардчилсан улс мөн л юм бол аль ч улс түүхэн замнал, бусдаас ялгагдах улс төр, нийгмийн ялгаанаасаа хамааралгүйгээр хууль цаазат төрийн удирдлагын гол бүрэлдэхүүн хэсэг болсон олонхын удирдлагыг хүний эрх, цөөнхийн эрхтэй хослуулсан төрийн жолоодлогын хэлбэртэй байх ёстой. Тэгэхлээр ардчиллыг нэгэн талаар Засгийн газрын үйл ажиллагааг хязгаарлах дүрэм журам, хэм хэмжээний цогцос хэмээн арай өргөн хүрээтэй зүйл гэж үзэх ёстой болж байна. Тодруулж хэлбэл, ардчилсан улсын эсийг бүрдүүлдэг улс төрийн сон олон нийтийн байгууллагын нэр хүнд, хууль ёсны байдлыг ардчилсан нийгэмд Засгийн газар тодорхойлдоггүй гэсэн үг юм.

Ардчилсан нийгэмд орон нутгийн чанартай болон нийт улсын царааны байгууллага олноороо гарч ирж болохыг бид нэгэнт мэдэрсэн. Эдгээр байгууллагын олонх нь хувь хүмүүс болоод төр, засаг захиргаа, бусад байгууллагын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байна.

Өөрөөр хэлбэл, тэдгээр байгууллага нь Засгийн газрын эрх мэдлээс ангид үүргийг гүйцэтгэн, иргэдэд ардчилсан улсын иргэний нь хувьд эрх үүргээ хэрэгжүүлэх боломж олгодог.

Эдгээр байгууллага нь гишүүдийнхээ эрх ашгийг янз бүрийн аргаар хамгаалдаг. Жишээлбэл, улс үндэсний хэмжээний чухал асуудлаар шийдвэр гаргахад нөлөө үзүүлэх зорилгоор нэр дэвшигчдийг сонгуульд дэмжих, хэлцэгдэж буй асуудлаар санал гаргах зэргийг дурдаж болно. Чухам эдгээр байгууллагын оролцоо тусламжид дулдуйлан төрийн болон орон нутгийн эрх барилцахад иргэд ухамсартайгаар оролцох өргөн боломжоор хангагддаг гэж хэлж болох ажээ. Гэтэл нэг хүний ч бай, бүлэг хүний ч бай дарангуй засаглалын үед төр засаг ямар нэгэн аргаар бүхнийг хатуу хяналтандаа барьж байдаг. Харин ардчилсан төрийн үед Засгийн газрын эрх мэдэл хуулиар нарийн тогтоогдож, эрс хязгаарлагдсан байдгаараа, үүнээс ялгаатай. Үүний үрээр улс төр, олон нийтийн дээрх байгууллагуудын олонх нь Засгийн газрын хяналтаас ангид оршихын зэрэгцээ түүний хувьд гаднаас нөлөөлөх хэрэгсэл болж, Засгийн газрыг өөрийнхөө үйл ажиллагааныхаа эцсийн хариуцлагыг даах чадвартай болгохыг оролдож байдаг байна.

Ардчиллын онолыг үндэслэгчдийн үзэж байснаар хүнээс салангид байлгаж огт болохгүй эрх буюу амьдрах, эрх чөлөө эдлэх, аз жаргалтай байх эрхээ л хангахын үүднээс хүмүүс өөрсдийгөө удирдах эрх бүхий Засгийн газар байгуулдаг ажээ. Тиймээс эдгээр эрхийг Засгийн газар иргэддээ бэлэглэж, хайр хишиг хүртээсэн мэтээр үзэж болдоггүй байна. Учир нь тэдгээр эрхийг хүмүүс хүн болж төрснийхөө хувьд байгалийн хайр ивээлээр олж авдаг ажээ. XVII—XVIII зууны соён гэгээрүүлэгчид, гүн ухаантнуудын тодорхойлсноор тэрхүү салгашгүй эрх нь бурхнаас заяасан онцгой эрх байдаг байна. Тиймээс иргэний ямар ч нийгэм, төр улс түүнийг устгах буюу өөрчлөх ёсгүй ажээ. Америкийн орчин үеийн улс төр судлаачдын үздэгээр ардчиллын үндэс дорх зүйлээс бүрддэг байна:

1. Үндэсний тусгаар тогтнол
2. Ард түмний зөвшөөрөлтэйгөөр ард түмнийг удирдах
3. Олонхын удирдлага
4. Цөөнхөө хүндэтгэх
5. Хүний үндсэн эрхийг баталгаажуулах
6. Чөлөөт шударга сонгууль
7. Хуулийн өмнө бүгд тэгш хариуцлага хүлээх
8. Хуулийг зохих ёсоор хэрэгжүүлэх
9. Засгийн газрын үйл ажиллагааг үндсэн хуулиар хязгаарлах
10. Нийгэм, эдийн засаг, улс төрийн олон ургальч үзэл
11. Ашиг сонирхол, хүлээц тэвчээр, хамтын ажиллагаа, эв зохицлын үзэл санаа юм.

Тэгэхлээр аливаа ардчилсан нийгэм иргэддээ олгож, Засгийн газар нь хамгаалах ёстой эрх нэлээд өргөн хүрээтэй байдаг байна. Тухайлбал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж үг хэлэх, итгэл үнэмшил шашин шүтлэг чөлөөтэй байх, жагсаал цуглаан чөлөөтэй хийх, хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байх зэргийн олон эрхийг дурдаж болно. Гэхдээ тэдгээр эрхийн гол сүнс нь шударга шүүхийг шаардах эрх гэдгийг мартаж болдоггүй бололтой. Эдгээр эрхийн зарим нэгтэй нь бид ямар нэгэн хэмжээгээр урьд нь танил байсан. Зарим нэгтэй нь одооноос танилцаад байна. Тэгэхлээр бидний хувьд шинэлэг бөгөөд учир нь бүрэн сайн олгогдохгүй байгаа зарим нэгэн эрхийн талаар бага боловч тодруулахыг оролдоё. Тухайлбал, иргэд чөлөөтэй үг хэлэх эрхийг ардчилсан нийгмийн амьдрах эрчим хүчний эх булаг гэж үздэг билээ. Гэтэл энэхүү эрх чөлөөг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бусад байгууллага

хэтрүүлэн эдэлж, хүн амын олонхын үзэж байгаагаар хов жив, гүтгэлэг, хуурамч мэдээлэл эх захгүй тарааж эхэлсэн нь бидний санааг зовоож, хэвийн бус үзэгдэл, ухаан санааны самуурал мэт сэтгэгдэл төрүүлэх боллоо. Энэ тохиолдолд Засгийн газар яах ёстой вэ? Үүнийг Засгийн газар ч, хүмүүс ч мэдэхгүй байна. Гэтэл Засгийн газар ийм тохиолдолд яах ч ёсгүй ажээ. Яагаад гэвэл энэ асуудал нь Засгийн газрын хийх ажилд тооцогддоггүй учир түүнтэй хутгалдах ёсгүй гэж ардчилсан нийгэмд үздэг байна. Энэ үг хүмүүст гайхал төрүүлж магадгүй. Харин ардчилсан нийгэмд амьдарч сурсан хүмүүс ил тод хэлэлцэн маргалдах нь үнэнийг илүү ихээр тодруулж, ухаалаг шийдвэр гаргах боломж өгдөг гэж үздэг ажээ. Тиймээс өөрөөр бодож сэтгэгчдийг дарахын оронд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг нь зөвшөөрөх, тэр ч битгий хэл ардчиллыг эсэргүүцсэн үг хэл гаргаж буй хүмүүс, бүлгийн үг хэлэх эрхийг хүртэл ардчиллын тусын тулд хамгаалдаг байна. Үүнийг «Олноороо хэлэлцвэл буруугүй» гэдэг ардын ухаанаар ойлгох ёстой бололтой.

Хоёрт, төр иргэний хоорондын харилцаа буюу иргэний эрх, үүргийн талаар товч тодруулахыг оролдъё. Ардчилсан нийгэмд хүн эрхээ эдлэхийн хажуугаар өөр болон бусдын төлөө тэрхүү эрхээ хамгаалах, болж өгвөл өргөтгөх үүрэгтэй гэж үздэг байна. Гэтэл ардчилал өндөр хөгжсөн оронд ч иргэд эрхээ илүү мэдэрч, үүргээ умартах явдал бишгүй тохиолддог. Тиймээс ч Америкийн улс төр судлаач Бенжамин Барбер «Ардчиллыг олонхын засаглал, эрхийг иргэдийн хувийн өмч мэтээр ойлгож, олонхын ардчилалд сэргүүлэн тавих хандлага улам бүр газар авч байна. Үнэндээ энэ нь эрх, ардчилал гэж чухам юу болохыг ойлгохгүй байгаа хэрэг юм» гэж бичжээ. Хүний эрх нь үнэхээр хувийн өмч биш юм. Тэрхүү эрх нь нийгмийн бусад гишүүнээр хүлээн зөв шөөрөгдөж байгаа учраас л оршин тогтнох чадвартай болсон хэрэг. Харин эрхийг хүмүүс эдэлж, хүмүүс хэрэгжүүлдэг учраас хоосон тунхаглаад орхивол амьдралд үйлчилдэггүй. Иргэд эрхээ хамгаалах нь Засгийн газрын эрх мэдлийг хязгаарлаж буй хэрэг бөгөөд энэ тохиолдолд хүний эрх нь Засгийн газар болоод эрх баригч улс төрийн олонхоос эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхийг эсэргүүцэх явдлын гол тулгуур болж байна гэж ойлгох нь зөв юм. Өөрөөр хэлбэл, энэ нь ард олноор сонгогдсон ардчилсан Засгийн газар хүний эрхийг хэрэгжүүлэгч биш хамгаалагч байх ёстойг үргэлж сануулагч хэрэгсэл гэсэн үг. Дахин давтан хэлэхэд, ардчилсан нийгмийн иргэд хүний эрхийг өргөжүүлэх үүрэг хариуцлагыг нийгмийнхээ өмнө хүлээдэг байна. Энэ үүрэг хариуцлага хэрэгжих явцдаа иргэдийг нийгмийн аливаа ардчилсан үйл явцад идэвхтэй татан оролцуулдаг далд чанартай гэж үздэг. Товчоор хэлбэл, нийгэмд тулгарсан аливаа ээдрээтэй асуудлыг иргэд өөрсдөө бие дааж шийдэн, учрыг нь олж хужрыг нь тунгаах чадвартай байх шаардлагатай. байдаг. Энэ бол мухар сохроор дагах явдлаас иргэдийг сэргийлэх нигүүлсэн зарчим мөн гэж үзэхээс өөр аргагүй.

Гуравт, нийгэмд хууль жинхэнэ ёсоор мөрдөгдөх тухайд хэдэн үг хэлье. Хуульзүйн систем чухам хэний эрх мэдэлд байгаагаас шалтгаалж эрх мэдлээ хэтрүүлэх, дарангуйлах явдал гардаг. Улсын нэрийн өмнөөс хүмүүсийг шоронд хатааж, хөрөнгийг нь хурааж, газар нутаг заан цөлж, тамлаж, алж бүрэлгэж байсныг бид мартаагүй. Ийм харгислалыг тодорхой учир шалтгаангүй шахам хийж байсан цаг үе ч бий. Энэ мэт харгислал ардчилсан нийгэмд байж таарахгүй нь ойлгомжтой. Аливаа улс нийгмийн хэв журмыг сахиулж, эрүүгийн гэмт хэргийг цээрлүүлэх чадвартай байх шаардлагатай боловч хуулийг хүчтэй болгох тэрхүү үйл ажиллагаа нь ил тод, ойлгомжтой байх ёстойгоос биш дарангуйлал, эсвэл улс төрийн зорилготой ов мэхэнд тул-

гуурлаж хэрхэвч таарахгүй. Товчоор хэлбэл, төр засагт хууль дүрмийг мөрдүүлэх арга хэрэгсэл хэзээ ч дутагддаггүй. Гагцхүү хувь хүний эрх төдийгүй нийгмийн ашиг сонирхлыг шударгаар хамгаалагч гэдгээ ард олондоо харуулахуйц аргаар л ажиллаж, итгэгдэхийг хичээх ёстой болдог байна. Харин ард түмэн төрийн төмөр нүүрийг мэдрэхгүй байж, эрх чөлөөтэй амьдрах боломж ардчилсан нийгэмд иргэний үүргээ ухамсартай биелүүлэх явдлаар баталгаажсан байдаг. Үүгээр ардчиллын тухай яриагаа өндөрлөж, ардчилсан сонгуулийн тухай товч яриа дэлгэе.

в) Ардчилсан сонгууль

Ардчилсан сонгуулийг төлөөлөх ардчиллын амин сүнс гэж хэлж болно. Яагаад гэвэл ардчилсан нийгэмд төр засгийн нэр хүнд зөвхөн ард түмний санал сэтгэгдлээр тодорхойлогддог. Энэхүү санал сэтгэгдлийн гол илрэл нь шударга болоод чөлөөт сонгууль гэж хэлж бүрэн болно. АНУ-ын эрдэмтэн Жин Киркпатрикийн тодорхойлсноор «ардчилсан сонгууль нь бэлгэдэл, ёс төдий зүйл байх ёсгүй» юм. Тиймээс ардчилсан сонгууль, нэгдүгээрт, өрсөлдөөнтэй байх ёстой. Сөрөг намууд, нэр дэвшигчид Засгийн газрын үйл ажиллагааг чөлөөтэй шүүмжлэхийн тулд үг хэлэх, жагсаал цуглаан зохион байгуулах боломжоор хангагдсан байхын дээр нийгмийн чухал асуудлын талаар зэрэгцээ бодлого дэвшүүлэх, хоёр дахь нэр дэвшигчийг гаргаж ирэх боломжоор хангагдсан байх ёстой. Эрх баригч нам эзэлж буй байр суурийнхаа улмаас олж авсан давуу талаа ашиглаж болох боловч сонгуулийг шударга бусаар явуулах учиргүй.

Хоёрдугаарт, ардчилсан сонгуулийг нэгэн хэмээр, тогтмол явуулах ёстой, Ардчилсан нийгэмд ерөнхийлөгчөө бүх насаар нь сонгодоггүй. Төр засгийн өндөр албан тушаалтнууд ард түмний өмнө тайлагнаж, хуулиар тогтоогдсон хугацаа нь дуусмагц сонгогчдын итгэлийг олж дахин сонгогдохоор тэдэнд хандахаас өөр аргагүй болдог. Энэ нь ардчилсан нийгэмд төр засгийн өндөр албан тушаалтнуудыг дураараа дургивал албан тушаалаас нь хугацаанаас нь өмнө буулгах боломж ард олонд байдгийн баталгаа юм.

Гуравдугаарт, ардчилсан сонгууль өргөн хүрээтэй явагдах ёстой. Дотоод байдал нь хэчнээн ардчилсан шинж төрхтэй байвч хүн амынхаа дархлагдсан цөөнхийн хэсгээр сонгогддог засаг төрийг ардчилсан гэж нэрлэх аргагүй байдаг учраас сонгогчид гэдэг нэрийн дор хүн амын насанд хүрсэн хэсэг бүгдээрээ хамаарагдахуйцаар өргөн хүрээтэй тодорхойлолт гаргаж, ажлаа хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

Дөрөвдүгээрт, ардчилсан сонгууль шийдвэрлэх шинжтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл, улс орныг хэн удирдахыг шийдэхэд ардчилсан сонгууль шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Ард олноор сонгогдсон удирдлага төрийн жолоог үндсэн хууль, бусад дүрэм журмын дагуу удирдах үүрэг хүлээдэг.

Эцэст нь хэлэхэд, ардчилсан сонгууль нэр дэвшигчдийг сонгосноор дуусгавар болчихдоггүй. Улс төрийн чухал асуудлыг шийдвэрлэхэд сонгогчид санал асуулга, санал хураалтад хэзээ ч татагдан оролцож болохоос гадна аливаа санаачилга гарган их бага ажилд шууд гар бие оролцох боломжтой байна.

АНУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД (Товч намтар)

1. Вашингтон, Жорж	1789-1797
2. Адамс, Жон	1797-1801
3. Жефферсон, Томас	1801-1809 Ардчилсан Нам (АН)
4. Мэдисон, Жеймс	1809—1817
5. Монро, Жеймс	1817—1825

6. Адамс, Жон Куинси	1825—1829
7. Жетисон, Эндрю	1820—1837
8. Ван-Бюрен, Мартин	1837 — 1841 АН
9. Гаррисон, Уильям Гэнри	1841 —III—IV сар АН, нас барсан
10. Тайлер, Жон	1841 — 1845 АН
11. Полк, Жеймс Нокс	1845—1849 АН
12. Тейлор, Закари	1849—1850 АН нас барсан
13. Филмор, Миллард	1850—1853 АН
14. Пирс, Франклин	1853—1857 - АН
15. Бьюкенен, Жеймс	1857—1861 АН
16. Линкольн, Авраам	1861—1865 АН, алагдсан
17. Жонсон, Эндрю	1865-1868 АН
18. Грант, Уилсс Симпсон	1869—1877 Бүгд Найрамдах Нам (Бнн)
19. Хейс, Разерфорд Бёрчард	1787—1881 БНН
20. Гарфилд, Жеймс Абрам	1881 —III—IV сар. БНН, алагдсан
21. Артур, Честер Алан	1881 — 1884 БНН
22. Кливленд, Стивен Гровер	1884—1888 АН
23. Гаррисон, Бенжам	1889— 1893 БНН
24. Кливленд, Стивен Гровер	1893 — 1897 АН
25. Мак-Кинли, Уильям	1897—1901 БНН, алагдсан
26. Рузвельт, Теодор	1901 — 1909 БНН
27. Тафт, Уильям Хоуард	1909 — 1913 БНН
28. Вильсон (Уильсон), Томас Вудро	1913—1921 АН
29. Гардинг, Уоррен	1921—1923 БНН, нас барсан
30. Кулик, Кальвин	1923—1929 БНН
31. Гувер, Герберт Кларк	1929—1933 БНН
32. Рузвельт, Франклин Делано	1933—1945 АН, нас барсан
33. Трумэн, Гарри	1945—1953 АН
34. Эйзенхауэр, Дуайт Дейвид	1953—1961 БНН
35. Кенеди, Жон Фицджералд	1961 — 1963 АН, алагдсан
36. Жонсон, Линдон	1963—1909
37. Никсон, Ричард Милхаус	1969—1974 БНН, огцорсон
38. Форд, жеральд Рудольф	1974—1976 БНН
39. Картер, Жеймс (Жимми) Эрл.	1976—1980 АН
40. Рейган, Рональд Уильсон	1981 — 1989 БНН
41. Буш, Жорж Герберт Уокер	1989 оноос БНН

1. Вашингтон, Жорж (1732—1799) АНУ-ын анхны ерөнхийлөгч, 1775--1783 онд Хойд Америкт болсон Их Британий колоничлолын эсрэг, тусгаар тогтнолын төлөө дайны гарамгай зүтгэлтэн энэ хүн Виржини муж улсын Вестморленд хэмээх тойрогт 1732 оны 2-р сарын 22-нд төржээ. 1749 онд дунд сургуулийг газар хэмжигчийн мэргэжлээр төгсөж, 1752 онд Виржинид цэргийн алба хаан хошууч болсон. 1758 онд Виржини муж улсын ассамблейд сонгогдож, 1774, 1775 онд болсон Америк тивийн I, II их хуралд төлөөлөгчөөр сонгогдож байв. 1715--1783 онд Америк тивийн конгрессийн гишүүн, тусгаар тогтнолын дайны үед Америкийн зэвсэгт хүчний ерөнхий командлагчаар ажиллаж байв. 1787 онд АНУ-ын үндсэн хуулийг батлах зохион байгуулах хурлын дарга, 1789-1797 онд АНУ-ын анхны ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байлаа. Тэрээр Францын хөрөнгөтний аугаа их хувьсгалын дүнд бүрэлдэн бий болсон нөхцөлд өөрийн байр суурийг тодорхойлсон юм. Үүнээс болж төрийн нарийн бичгийн дарга Т. Жефферсон, Сангийн яамны сайд А. Гамильтонтой зөрөлдөж байжээ. 1799 оны 12-р сарын 14-нд нас барсан. 1800 оны 12-р сарын 1-нд АНУ-ын нийслэлийг түүний нэрээр нэрлэсэн ажээ.

2. Адамс, Жон (1735—1826)-АНУ-ын хоёр дахь (1797—1801) ерөнхийлөгч, дипломат, Английн колоничлогчдын эсрэг тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийн дотроос товойн гарсан зүтгэлтний нэг. Тэрээр уран илтгэгч, авьяаслаг хошин шогч байжээ. 1774—1777 онд конгрессийн гишүүн, 1776—1777 онд АНУ-аас гадаад орнуудтай дипломат харилцаа тогтоох хорооны гишүүн, 1777 оны 12-р сараас Парист дипломат төлөөлөгчөөр, 1790 онд Гадаад элчин сайдаар ажиллаж, 1782 оны 4-р сард Голланд АНУ-ыг хүлээн зөвшөөрч худалдааны гэрээ бай-

гуулахад гол үүрэг гүйцэтгэсэн. Тусгаар тогтнолын дайн дуусаж Англитай Версальд энх тайвны гэрээ (1783) байгуулахад оролцож, 1785-1788 онд Англид суух АНУ-ын анхны элчин сайдаар томилогдон ажиллаж байв. Англи-Францын дайны үеэр Америкийн худалдааны онгоц руу францчууд халдсанаас болж хоёр орны харилцаа хурцадсаны улмаас танхимын гишүүд санал зөрөлдөхөд Ж. Адамс дээрх дайнд АНУ-ын төвийг сахих байр суурийг хамгаалахын чухлыг шаргуу шаардаж, 1800 онд АНУ-Францын хооронд дипломат харилцааг сэргээсэн байна.

3. Жефферсон, Томас (1743—1826) Альбемарл хотод төрсөн. АНУ-ын төрийн томоохон зүтгэлтэн, дипломат. «Тусгаар тогтнолын тунхаглал»-ыг зохиогч, хожим Ардчилсан хэмээн нэрлэгдсэн намыг үндэслэгч, 1779—1782 онд Виржини муж улсын захирагч, 1784—1789 онд Парист элчин сайд, 1790—1793 онд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга, 1797 оноос дэд ерөнхийлөгч, 1801—1809 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байв. Т. Жефферсон тусгаар тогтнолын дайны жилүүдээс эхлээд насан эцэслэтлээ, өөрөөр хэлбэл, бараг хагас зуун жил АНУ-ын гадаад бодлогод гол нөлөө үзүүлсэн хүн. Парист элчин сайд байхдаа Францын хувьсгалчдын гол зөвлөгч байлаа. Чухамхүү «Тусгаар тогтнолын тунхаглал»-ыг үлгэр болгон францчууд «Францын хүн ба иргэний эрхийн тунхаглал»-аа зохиожээ.

1793 онд Францын хувьсгалын эсрэг Англи тэргүүтэй эвслийнхний хийсэн дайнд ерөнхийлөгч Ж. Вашингтон улс орон бэхжээгүй нөхцөлд төвийг сахих нь гарцаагүй гэж үзэж байв. Т. Жефферсон үүнийг эсэргүүцэж, 1778 онд Францтай байгуулсан гэрээг монархитай биш, харин Франц улстай байгуулсан юм гэдгийг нотлохын хамт энэ дайнд Францын талд зогсохыг уриалж байлаа. 1793 оны 4-р сарын 22-нд Ж. Вашингтон төвийг сахих тунхаглалыг конгрессоор батлуулсан учир тэр төрийн нарийн бичгийн даргаасаа өөрөө огцорсон байна. Тэр АНУ-ын гадаад бодлого бол «Энх тайван, найрамдал, худалдааны бодлого байх ёстой гэж үзэж байжээ. Т. Жефферсон 1826 оны 7-р сарын 4-нд АНУ байгуулагдсаны болон «Тусгаар тогтнолын тунхаглал» боловсруулсны 50 жилийн ойн өдөр 83 насандаа таалал төгсжээ.

4. Мэдисон, Жеймс (1751—1836) Виржини муж улсын Порт-Қануэй хотод төрсөн. Тусгаар тогтнолын төлөө дайнд 1787 оны Америкийн үндсэн хуулийн төсөл зохиоход идэвхтэй оролцсон. Холбооны (Ардчилсан) намын талд ажиллаж байгаад БНН-ынхантай нийлж конгрессийн баруун жигүүрийг тэргүүлж байлаа. 1789—1797 онд төлөөлөгчдийн танхимын гишүүн, 1801—1809 онд ерөнхийлөгч Т. Жефферсоны Засгийн газрын төрийн нарийн бичгийн дарга, 1809—1817 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байв.

5. Монро, Жеймс (1758—1831) Виржини муж улсын Вестморленд хотод боолын аж ахуйн эзний гэр бүлд төрсөн, ерөнхийлөгч Ж. Мэдисоны үед АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга (1811—1817), 1814-1815 онд Цэргийн яамны сайд, 1817—1825 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байв. 1823 онд АНУ-ын гадаад бодлогын үндсэн зарчмыг тунхагласан нь түүхэнд «Монрогийн номлол» хэмээн нэрлэгдсэн юм. «Монрогийн номлол»-ын гол агуулга нь дэлхийн нутаг дэвсгэрийг Америкийн ба Европын системд хуваахад чиглэгджээ. Америкийн системд Өмнөд, Умард Америк бүхэлдээ орох бөгөөд АНУ энэ бүс нутагт асуудлыг бүрэн шийдэж байх ажээ. XIX зууны сүүл хх зууны эхэн үеэс сайхь номлол пан Америкийн (аугаа их) үзлийн онолын үндэс болж, АНУ-ын гадаад бодлогод хөдөлбөргүй мөрдөгдөж байлаа.

6. Адамс, Жон Куинси (1767—1848) — Америкийн төрийн зүтгэлтэн, дипломат, хэвлэн нийтлэгч; ерөнхийлөгч Жон Адамсын төрсөн дүү, Ев-

ропыг сайн судалсан хүн. Янз бүрийн оронд эцэгтэйгээ нэг биш удаа хамт явж байсан. Бүр 15 настайдаа Орос оронтой танилцжээ. Тэрээр 1794—1797 онд Нидерландад элчин, 1797—1800 онд Прусст элчин сайдаар томилогдон Америк-Пруссийн хооронд найрамдал, худалдааны гэрээ байгуулсан. 1803—1808 онд сенатч, 1809—1814 онд АНУ-аас Орост суух анхны элчин сайдаар Петербург хотноо томилогдон ажиллаж байв. 1815—1817 онд Их Британид элчин сайд, 1817—1825 онд АНУ-ын төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж, Куба, Техасыг АНУ-д нэгтгэх талыг баримтлан «Монрогийн номлол»-ыг боловсруулахад оролцсон. 1825—1829 онд АНУ-ын ерөнхийлөгч, 1831—1848 онд төлөөлөгчдийн танхимын гишүүн байв.

7. Жексон, Эндрю (1776--1845) - АНУ-ын төрийн зүтгэлтэн, Ардчилсан намын гишүүн. 1797 онд сенатч, 1821 онд Флоридаг худалдан авсны дараа тус муж улсын захирагч болж, 1829 оны сонгуульд эндээс нэрээ дэвшүүлж ялалт байгуулан ерөнхийлөгчийн тушаалд 1837 он хүртэл ажилласан. Тэр анх удаа Дорно дахины улс оронтой дипломат харилцаа тогтоох талаар шийдвэртэй алхам хийж өөрийн дипломат тусгай төлөөлөгчийг Филиппин, Кантон, Аннам (Вьетнам), Сиамд (Тайланд) илгээж амжилтад хүрсэн хүн. Ерөнхийлөгч байх сүүлийн жилүүддээ Мексикээс Техасыг салгаж, АНУ-д нэгтгэх талаар шаргуу ажиллажээ.

8. Ван-Бюрен, Мартин (1782—1862) - АН-ын зүтгэлтэн, Э.Жексоны үед төрийн нарийн бичгийн дарга (1829 оноос), 1833-1837 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч, 1837—1841 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр тус тус сонгогдон ажиллаж байв.

9. Гаррисон, Уильям Гэнри (1773—1841) — АН-ын гишүүн, 1812 1814 оны Англи-Америкийн дайны үед Америкийн армийн командлагч, генерал цолтой байв. 1840 оны ерөнхийлөгчийн сонгуульд ялсан боловч (1841 оны 3—4-р сар) энэ тушаалд нэг сар л ажилласан юм. 4-р сард нас барсан.

10. Тайлер, Жон (1790 --- 1862) — АНУ-ын төрийн зүтгэлтэн, АН-ын гишүүн. Боолын эздийн эрх ашгийг илэрхийлэгч. 1828 оноос сенатч, 1840 оны 3-4-р сард дэд ерөнхийлөгч, У. Гаррисоныг нас барсны дараа АНУ-ын ерөнхийлөгч болсон (1841 — 1845). Боолын эздийн ашиг сонирхлыг илэрхийлсэн бодлого явуулж, шинэ газар оронд боолчлол дэлгэрүүлэхийг идэвхтэй дэмжиж байлаа 1861—1865 оны иргэний дайн эхэлсний дараа конгресст сонгогдож байв.

11. Пол, Жеймс Нокс (1795--1849) —1839—1841 онд Теннесси муж улсын захирагч, 1841 — 1845 онд төлөөлөгчдийн доод танхимын дарга, 1845—1849 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдон (АН-аас) ажиллаж байв. 1846 онд Колумбид халдан довтолж газар нутгийнх нь бараг талыг эзэлсэн. Мексикийн эсрэг түрэмгийлэлд идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн. Боолын эздийн эрх ашгийг илэрхийлсэн бодлого явуулж байв.

12. Тейлор, Закари (1784 — 1850) --АНУ-ын төр, цэргийн зүтгэлтэн, томоохон боол эзэмшигч. 1808 онд Америкийн цэрэгт алба хааж, индианчуудын эсрэг түрэмгийлэлд оролцсон. 1846—1848 оны Мексикийн эсрэг түрэмгийлэлд Америкийн армийг командалж байв. Үүний дүнд АНУ Мексикийн газар нутгийн бараг талыг нэгтгэжээ. 1849—1850 онд АНУ-ын ерөнхийлөгч (АН-аас) болж, өмнөдийн боол эзэмшигчдийн эрх ашгийг илэрхийлсэн бодлого явуулж байв. 1850 онд Тейлорын засаг захиргаа Англитай далайн сувагт хяналт тавих тухай гэрээ байгуулжээ.

13. Филмор, Миллард (1800 — 1847)-АН-ын зүтгэлтэн, 1848 онд дэд ерөнхийлөгчөөр сонгогдож 1849— 1850 он хүртэл энэ тушаалд ажиллаж байгаад 3. Тейлорыг нас барсны дараа АНУ-ын ерөнхийлөгч

болсон (1850—1853). АНУ-д боолчлолыг хэвээр хадгалах талын хүн. М. Филмор капитализм хөгжсөн умард, боол эзэмшигч Өмнөдийн хооронд түр эвлэрэл тогтоох талаар нэлээд идэвх гаргаж амжилтад хүрчээ. Үүний дунд 1850 онд Калифорни боол эзэмшээгүй муж улсын холбоонд орсон байна. Гэвч 1861 — 1865 онд иргэний дайны үед М. Филмор боол эзэмшигчдийн талд орсон юм.

14. Пирс, Франклин (1804 — 1869) —АН-ын зүтгэлтэн, генерал цолтой. 1833 онд Конгрессын гишүүн болсон. Мексикийн эсрэг дайнд оролцсон (1846—1848). 1853-1857 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж, боолын эздийн ашиг сонирхолд нийцсэн бодлого явуулж байлаа.

15. Бьюкенен, Жеймс (1791-1868) — Төрийн зүтгэлтэн, дипломат. Пенсильвани муж улсын Мерсерсберт хотод төрсөн. 1821 онд конгрессын гишүүн, дараа нь Пенсильвани муж улсаас дэвшигдсэн сенатч, 1832--1833 онд Петербурgt элчин сайд, 1845—1849 онд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга байв. 1846 онд Мексикийн эсрэг түрэмгийллийг зохион байгуулсан. 1857—1861 онд АН-аас дэвшин АНУ-ын ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ.

16. Линкольн, Авраам (1809—1865) — Америкийн төрийн хамгийн гарамгай зүтгэлтэн, Кентукки муж улсад фермийн эзний гэр бүлд төрсөн. Залуу байхдаа түлээ мод огтлогч, Огайо гол дээр гаталгагч, Миссисипийн ачаа тээврийн газарт хайлшчинаар ажиллаж байв. Шаргуу хөдөлмөрлөж, биеэ даан боловсрол эзэмшин 27 насандаа өмгөөлөгчийн мэргэжлээр шалгалт өгч тэнцсэн. 1834—1841 онд Иллинойс муж улсын хууль тогтоох хурлын гишүүн, 1847-1848 онд конгрессын гишүүн байв. Түүнийг ерөнхийлөгч байх үед (1861—1865 он) Америкийн умард, өмнөдийн хооронд иргэний дайн болсон билээ. А. Линкольн, үеэ өнгөрөөсөн боолын аж ахуй ноёрхож байсан боол эзэмшигч өмнөд мужийн эсрэг тэмцэж АНУ-д хөрөнгөтний ардчиллыг тогтоосон хүн, Үүнийг бас АНУ-ын хоёр дахь хувьсгал гэж ч нэрлэдэг. 1864 онд АНУ ын ерөнхийлөгчөөр хоёр дахь удаагаа сонгогджээ.

К. Маркс I интернационалд ажиллаж байхдаа Өмнөдийн боол эзэмшигчдийн эсрэг А. Линкольны явуулж байсан тэмцэлд баяр хүргэсэн цахилгаан утас илгээж байлаа. А. Линкольн боол эзэмшигч өмнөд мужийн нийслэл Ричмондог эзэлсний дараа 1865 оны 4-р сарын 15-нд тэдний тагнуулчдын гарт хорлогдсон байна.

17. Жонсон, Эндрю (1805— 1875) — Умард Каролины Роли хотод төрсөн, 1830-аад оны сүүлээс АН-ынхантай нийлсэн. 1861 — 1865 оны иргэний дайны үед Теннесси муж улсын цэргийн захирагч (1862), мөн муж улсын захирагчаар томилогдон ажиллаж байв. 1865 оны 3—4-р сард АНУ-ын дэд ерөнхийлөгч, ерөнхийлөгч А. Линкольныг алагдсаны дараа АНУ-ын ерөнхийлөгч болсон (1865—1868).

18. Грант, Уилсс Симпсон (1822-1885) —Пойнт-Плегант хотод худалдаачны гэр бүлд төрсөн. 1843 онд Узст-Пойнтын цэргийн академи төгссөн. 1846 — 184.8 онд АНУ-аас Мексикийн эсрэг дайнд оролцож, 1861-1865 оны иргэний дайнд сайн дурынхны Иллинойсын хорооны даргаар ажиллаж байв. 1861 оны 8-р сард бригадын генерал, 1864 оны 3-р сард хуурай замын цэргийн хүчний дэслэгч генерал цолоор шагнагдаж, Холбооны армийн ерөнхий командлагчаар томилогдон 1869 1877 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр (БНН-аас) ажиллаж байхдаа БНН ынхны радикал үзэлтнүүдийг дэмжсэн бодлого явуулж байв. Түүний үед хээл хахууль, дамын наймаа газар авсан байна.

19. Хейс, Разерфорд, Бёрчард (1822-1893)-Огайо муж улсын Делавэр хотод төрсөн, хуульч, 1861—1865 оны иргэний дайнд идэвхтэй оролцсон. 1864 онд БНН-аас конгресст сонгогдсон. 1867 онд Огайо

муж улсын захирагч болж, 1869, 1875 онд дахин сонгогдсон. 1877 1881 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр ажиллаж байлаа.

20. Гарфилд, Жеймс Абрам (1831-1881) — Огайо муж улсын Оринжи хотод фермийн эзний гэр бүлд төрсөн. Иргэний дайны үед ерөнхийлөгч А. Линкольны армийн командлагчдын нэг байв. 1862 онд конгрессын гишүүнээр сонгогдсон. 1870-аад онд төлөөлөгчдийн танхимд БНН-ынхныг тэргүүлж байв. 1880 онд болсон ерөнхийлөгчийн сонгуульд хурц ширүүн тэмцлийн дунд ялсан. Гэвч 1881 оны 3-р сарын 17-нд хүнд шархдаж, мөн оны 5-р сарын 2-нд амь насанд нь дахин халдсаны улмаас нас баржээ.

21. Артур, Честер Алан (1830— 1886) -БНН-ын зүтгэлтэн, Вермонт муж улсын Фэрфилд хотод төрсөн, хуульч 1880 онд дэд ерөнхийлөгчөөр сонгогдон (1881 оны 7-р сараас 1885) ажиллаж байв.

22. Кливленд, Стивен Гровер (1887—1908) — Нью-Жерси муж улсын колдуэл хотод төрсөн, хуульч. 1885—1889, 1893—1897 онд АНУ ын ерөнхийлөгчөөр ажиллаж байв. 1893 онд алтны стандартыг сэргээж, 1894 онд тарифын шинэ журам баталсан, С. Кливлендийн засаг захиргаа ажилчдын эсрэг хамгийн харгис бодлого явуулсан юм. Тэр 1886 онд Чикаго хотод болсон майн нэгний ажилчдын сүрт жагсаалыг буудахыг тушаажээ. Гадаад бодлогын салбарт «Аугаа их Америкийн үзэл» гэгчийг номлож байв. Америкийн тэнгисийн цэргийн хүчирхэг флот байгуулах өргөн хүрээтэй программ боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн.

23. Гаррисон, Бенжам (1833--- 1901) --Огайо муж улсын Норт-Бенд хотод төрсөн. Ерөнхийлөгч Уильям Г, Гаррисоны ач, хуульч. 1889 1893 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байв. Тэр сан хүү, аж-үйлдвэрийн ашиг сонирхлыг тусгасан хэд хэдэн хууль конгрессоор батлуулан гаргасан. Тэр Америкийн улсуудын гаалийн холбоо байгуулах зорилгоор 1889 онд Пан-Америкийн анхдугаар бага хурлыг санаачилсан юм.

24. Кливленд, Стивен Гровер. 1893—1897 онд дахин сонгогдсон.

25. Мак-Кинли, Уильям (1843—1901) — Огайо муж улсын Найлст хотод төрсөн. 1877 оноос конгрессын гишүүн, 1890 онд түүний санаачилгаар бараа нэвтрүүлэхэд гаалийн тариф нэмэгдүүлэх тухай хууль батлан гаргаж, нийтэд эрэлт ихтэй барааны үнийг нэмсэн. 1896 онд БНН-аас ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлж ялсан. 1901 оны 9-р сарын 6-нд хүнд шархдаж, мөн сарын 14-нд нас барсан.

У. Мак-Кинлийн засаг захиргаа 1898 оны Испани-Америкийн дайныг дэгдээн, 1899 онд Хятадад «Нээлттэй хаалга»-ны бодлого гэдгийг анх удаа тунхагласан байна.

26. Рузвельт, Теодот (1858-1919) --Нью-Йоркт баян айлын гэр бүлд төрсөн, хууль, эрхийн боловсрол эзэмшсэн хүн. 1880-аад оноос БНН-ын нэрт зүтгэлтэн болж, 90-ээд оноос сенатч Лож, Бивериж нартай хамт БНН-ын бүлгийг толгойлж байв. Мөн 1885—1887 онд Нью Иоркийн цагдаагийн департаментын ерөнхийлөгчөөр ажиллаж, 1887 онд Тэнгисийн яамны сайдын туслах, 1898 оноос Нью-Йорк муж улсын захирагч, 1901 оны 3-р сараас АНУ-ын дэд ерөнхийлөгч, мөн оны 9-р сараас алагдсан ерөнхийлөгч У. Мак-Кинлийн оронд ерөнхийлөгч болж 1909 он хүртэл ажилласан.

Дотоод бодлогын хувьд хөрөнгөтний шинэтгэлийг тууштай явуулсан. Гадаад бодлогын салбарт 1898 оны Испани-Америкийн дайныг дэгдэхэд гол үүрэг гүйцэтгэж, Латин Америкт «том бороохойн» бодлогыг тунхаглаж, 1902-1903 онд Венесуэлийн хямрал гарахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн 1901 онд Кубыг хаан боох бодлого явуулж 1906—1909 онд Кубад АНУ-ын цэргийн эзэмшлийг тогтоосон. 1903 онд

Бүгд Найрамдах Панам улс байгуулагдсаны дараа довтолж, 1904 1905 оны Орос-Японы дайны үед Японыг санхүү дипломатын талаар дэмжиж байв.

27. Тафт, Уильям Хоуард (1857—1930) -Огайо муж улсын Цинциннати хотод төрсөн, хууль эрхийн боловсролтой. 1896—1900 онд Йелийн Их сургуулийн профессор, 1900—1901 онд Филиппинд АНУ-ын ноёрхлыг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулж Филиппиний комиссын даргаар ажиллаж байв. 1901 — 1904 онд Филиппин мужийн захирагч, 1904 1908 онд Цэргийн яамны сайд, 1909—1913 онд АНУ-ын ерөнхийлөгч (БНН-аас) болсон. 1905 оны Япон-Америкийн хэлэлцээрт оролцсон. 1906 онд Кубад өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дарах ажлыг удирдсан. 1912 онд Никарагуагийн эсрэг интервенц хийсэн. 1913 1921 онд Йелийн их сургуулийн профессор, 1921 оноос АНУ-ын Дээд шүүхийн даргаар ажиллаж байв. Тэр ЗХУ-тай дипломат харилцаа тогтоохын эсрэг байсан юм.

28. Вильсон (Уильсон), Томас Вудро (1856—1924) -Стантон хотод төрсөн. 1897 онд Принстоны Их сургууль төгссөн. 1886 онд философийн ухааны докторын зэрэг хүртсэн, 1890—1902 онд Принстоны их сургуулийн профессор болж түүх, төрийн эрхээр лекц уншиж байлаа. 1902—1910 онд Принстоны Их сургуулийн ректороор ажиллаж байв. АНУ-ын түүхийн талаар олон ном бичсэн. 1910—1912 онд Нью-Жерси муж улсын захирагчаар ажиллаж байхдаа дэвшилт шинэтгэл хийж нэрд гарсан. Тиймээс түүнийг «шинэтгэгч» гэж нэрлэж байв. 1912 онд АН-аас сонгуульд нэрээ дэвшүүлэн, дөнгөж 40 хувийн санал авсан боловч БНН-ын дотор хагарал гарсан учир тэрээр сонгуульд ялалт байгуулж чаджээ. Тийнхүү АНУ-ын ерөнхийлөгчөөр 1921 он хүртэл ажилласан юм.

Ерөнхийлөгч болсон анхны жилээсээ эхлэн нөөц банкны тухай, албан татварын дэвшилт хууль конгрессоор батлуулан гаргасан. Түүнийг нь «Шинэ эрх чөлөөний эрин» гэж нэрлэж байв. Гадаад бодлогын салбарт АНУ-ын монопольт хөрөнгөтний эрх ашгийг илэрхийлсэн түрэмгий бодлогыг Алс Дорнод, Латин Америкт явуулж байлаа. 1914, 1916—1917 онд Мексикт довтолж, 1915 онд Гаитид, 1916 онд Сан-Доминг-д АНУ-ын эзэмшлийг тогтоосон. Дэлхийн I дайнд төвийг сахиж байсан боловч 1917 оны 4-р сард Германд дайн зарласан. Орос оронд Зөвлөлт засаг тогтсоны дараа Зөвлөлт Орос улсын эсрэг цэргийн интервенц хийхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэж, Алс дорнодод Америкийн цэргийг буулгасан. Версалийн найрамдлын гэрээнд гол зохицуулагч болохын хамт Парисын бага хуралд олон улсын харилцаанд Америкийн эрх ашиг, ноёрхлыг бэхжүүлэхэд чиглэсэн 14 зүйлт «энх тайвны программ» гэгчийг дэвшүүлж байв.

29. Гардинг, Уоррен (1865—1923) - Огайо муж улсын Корсика, одоогийн Блуминг-Гров хотод төрсөн. Улс төрийн үйл ажиллагаагаа муж улсын сонины газраас эхэлсэн. БНН-ын гишүүн. 1920 оны ерөнхийлөгчийн сонгуульд Б. Вильсоны эсрэг «Дундаж америкчуудын төлөө» хэмээх лоозон дэвшүүлэн амжилт олж, АНУ-ын ерөнхийлөгчөөр 1923 он хүртэл ажиллажээ. 1921—1922 онд болсон Вашингтоны бага хурал бол У. Гардингийн дипломат үйл ажиллагааны хамгийн гол үйл явдал юм. Гэхдээ тэрээр хурлыг нээснээс өөр ажиллагаанд оролцоогүй. Тэр бага хуралд Зөвлөлтийн төлөөлөгчид оролцохыг татгалзсан юм. 1921 оны 5-р сард Зөвлөлт Орос Улсын БХТГХ-оос АНУ-ын конгрессын нэр дээр хоёр орны хооронд худалдааны харилцаа сэргээх тухай хүсэлтээ илэрхийлсэн цахилгаан утас илгээхэд У. Гардинг 30У «Нийгмийн системээ өөрчлөөгүй цагт» харилцааг сэргээхгүйгээд уг хүсэлтийг хэрэгсээгүй юм.

30. Кулиж, Кальвин (1872—1933) — Вермант муж улсын Плимута хотод төрсөн. Өмгөөлөгчийн мэргэжилтэй. БНН-ын хамгийн харгис зүтгэлтний нэг. 1921 оноос АНУ-ын дэд ерөнхийлөгч, ерөнхийлөгч У. Гардингийг нас барсны дараа түүний оронд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдон 1924 онд сонгуулиар дахин сонгогдож 1929 он хүртэл ажил ласан. К. Кулиж олон улсын тавцан дээр АНУ-ын нөлөөг эрс идэвхжүүлж, дэлхийн зах зээлд өөрийн орны манлайлах үүрэг, цэргийн нөлөөг бэхжүүлэхийг эрмэлзэж байлаа. ЗХУ-тай дайсагнагч байр сууринаас хандаж, Латин Америкт түрэмгийлэн, Мексикийн дотоод хэрэгт оролцож, Никарагуад цэргийн интервенц хийж байлаа. Тэр конгресст хэлэхдээ: «АНУ-ын иргэдийн эд хөрөнгө зөвхөн Америк улс оронд төдийгүй мөн хилийн чанадад оршиж байна» гэжээ.

(Үргэлжлэл бий)